

**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2019 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 02

Мандалговь

Г Сумдын Тусгай сангуд болон Төсвийн байгууллагууд ОНӨААТҮГ-ын 2018 он, 2019 оны санхүүгийн үйл ажиллагааны баримтанд хийсэн шалгалтын дүнгийн тухай

Дотоод аудитын хорооны хурлаар баталсан 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Албаны даргын удирдамжийн дагуу 15 сумын Тусгай сангуд болон Төсвийн байгууллагууд, ОНӨААТҮГ-дад төлөвлөгөөт шалгалтыг хөрөнгийн захиран зарцуулалт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан тэнцлийн гаргалт, үйл ажиллагааны орлого бүрдүүлэлт, зарцуулалт, Шилэн дансны цахим сүлжээнд мэдээллээ хэрхэн байршуулсан байдалд хийсэн санхүүгийн хяналт шалгалтын тайланг хэлэлцсэн Дотоод аудитын хорооны 2019 оны 11 дүгээрр сарын 22-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Тусгай сангуд болон төсвийн байгууллагууд, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот байгууллагын орлогын төлөвлөлт, зарцуулалтын байдал, Төсвийн болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль түүнтэй холбогдон гарсан заавар, журмын хэрэгжилтийн дунд илэрсэн болон шалгалтын танилцуулга, акт, албан шаардлагад дурьдагдсан зөрчил дутагдлыг арилгах, холбогдох хууль, тогтоомж, заавар журмыг мөрдөж зөрчил дутагдал гаргахгүй ажиллахыг шалгагдсан байгууллагуудын төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарт даалгасугай.

Хоёр. Санхүүгийн хяналт шалгалтаар улсын байцаагч нарын санхүүгийн зөрчилд тавьсан актуудыг 1 дүгээр хавсралтад дурьдсаны дагуу баталгаажуулсугай.

Гурав. Байгууллагуудын санхүүгийн эрсдлийг үнэлсэн үнэлгээг 2 дугаар хавсралтад дурьдсаны дагуу баталгаажуулж их эрсдэлтэй байгууллагуудыг ирэх оны төлөвлөгөөндөө тусган дахин шалгахыг Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга /Г.Зоригт/-т үүрэг болгосугай.

Дөрөв. Шалгалтын танилцуулга, акт, албан шаардлагад дурьдагдсан зөрчлийг дахин давтан гаргасан тохиолдолд холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцож ажиллахыг төсвийн ерөнхийлөн болон төсвийн шууд захирагч нарт даалгасугай.

Тав. Санхүүгийн хяналт шалгалтаар өгөгдсөн зөвлөмжийг хангах арга хэмжээний төлөвлөгөөг гарган, түүнийг хэрэгжүүлж, улмаар акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хагас, бүтэн жилээр Санхүүгийн хяналт, аудитын албанад тайлагнахыг Төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт даалгасуй.

490119001

Зургаа. Тогтоолоор өгөгдсөн үүрэг, акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаагүй нөхцөлд дараагийн шатны арга хэмжээ авах асуудлыг боловсруулж хорооны хуралд оруулан шийдвэрлүүлэхийг аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн дарга /Б.Түвшинбаяр/, Санхүүгийн хяналт аудитын албаны дарга /Г.Зоригт/-т нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД ДОТООД АУДИТИН  
ХОРООНЫ ДАРГА О. БАТ-ЭРДЭНЭ

